



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 05 сарын 00 өдөр

Дугаар 81199

Улаанбаатар хот

Үндэсний баг томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.6, 8.1.7, 8.1.9, 8.1.21, 8.1.24 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол Улсад нэн шаардлагатай тусlamж, үйлчилгээний хүrtээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах, хүлээгдлийг бууруулах зорилгоор бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд төрөлжсөн мэргэшлийн тuslamж, үйлчилгээг аймаг, дүүрэгт бэхжүүлэх, гадаад улсад эмчлүүлэх иргэдийн урсгалыг бууруулах зорилго бүхий "Хүүхэд нярай"-н үндэсний багийг нэгдүгээр, "Хүүхэд нярай, ургийн мэс засал"-ын үндэсний багийг хоёрдугаар, "Үндэсний багийн ажиллах удирдамж"-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үндэсний багт шаардагдах лабораторийн урвалж, оношлуур, эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, гадаад улсад багаар сургах судалгааг гаргах, орон нутаг, дүүрэгт хийх сургалт, үндэсний багийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тuslamжийн бодлогын газрын дарга (Р.Гантуяа), Үндэсний багийн ахлагч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Үндэсний багт шаардагдах лабораторийн урвалж, оношлуур, эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн орон нутаг, дүүрэгт хийх сургалт, гадаад улсад багаар сургах зардлыг хангах, ашиглалт, чанар аюулгүй байдалд хяналт тавьж ажиллахыг Стратеги төлөвлөлтийн газар (П.Оюунцэцэг), Санхүү, эдийн засгийн бодлогын газар (Э.Мөнхсүх)-т тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД



Т.МОНХСАЙХАН

121251022

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
..... сарын 05 өдрийн 10 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ХҮҮХЭД, НЯРАЙН ҮНДЭСНИЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч:

Ш.Энхтөр, Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төвийн зөвлөх эмч, Хүүхдийн эрчимт эмчилгээний эмч

Нарийн бичгийн дарга:

Ц.Ариунчимэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Сургалт сурталчилгааны албаны дарга, Хүүхдийн эрчимт эмчилгээний эмч

Б.Бүдсүрэн, Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төвийн Хүүхдийн цочмог эмгэг судлалын тасгийн эмч

Гишүүд:

У.Цэвэгмид, Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төвийн Хүүхдийн эмнэлэг хариуцсан дэд захирал, Хүүхдийн уушгинь эмч

М.Баялаг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албаны дарга, Хүүхдийн эмч

Ч.Наранцэцэг, Нярайн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч, Нярайн эмч

Т.Хаш-Эрдэнэ, Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төвийн эрчимт эмчилгээний эмч, Хүүхдийн эрчимт эмчилгээний эмч

Д.Агиймаа, Анаагаахын Шинжлэх ухааны үндэсний Их сургуулийн Хүүхдийн тэнхимиийн багш, Хүүхдийн бөөрний эмч

Б.Мягмарсүрэн, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн эрчимт эмчилгээний тасгийн эмч, хүүхдийн эрчимт эмчилгээний эмч

Л. Ролзодмаа, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нярай судлалын тасгийн эрхлэгч, Нярайн эмч

Ш.Чимгээ, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн нярайн зөвлөх эмч, Нярайн эмч

Ч.Дэлгэрцэцэг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Цусны эмгэг, хавдар судлалын тасгийн эрхлэгч, Хүүхдийн цусны эмгэг, хавдар судлалын эмч

Б.Ариунтунгалаг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нярай судлалын тасгийн эмч, Нярайн эмч

Э.Наранцацral, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн зөвлөх поликлиникийн тасгийн эрхлэгч, Хүүхдийн зүрхний эмч

Ч.Наранчимэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн тусlamж үйлчилгээ хариуцсан чанарын менежер, Хүүхдийн дотоод шүүрлийн эмгэг судлалын эмч

Б.Хандмаа, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын тасгийн эрхлэгч, Хүүхдийн хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын эмч

Н.Баярмаа, Улсын гуравдугаар төв эмнэлгийн хүүхдийн зүрхний судсан дотуурх мэс заслын эмч

Б.Ариунхишиг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Амьсгалын эрхтний эмгэг судлалын тасгийн эрхлэгч, Хүүхдийн уушгини эмч

Н.Дарьсүрэн, Анаагаахын Шинжлэх ухааны үндэсний Их сургуулийн Хүүхдийн тэнхимиийн багш, Хүүхдийн эрчимт эмчилгээний эмч

О.Солонго, Анаагаахын Шинжлэх ухааны үндэсний Их сургуулийн Хүүхдийн тэнхимиийн багш, Хүүхдийн уушгини эмч

Г.Одонтуяа, Эх нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төвийн Хүүхдийн Цочмог Эмгэг Судлалын Тасгийн эрхлэгч

Ц.Алтантуяа, Интермед эмнэлгийн Нярайн зөвлөх эмч, Нярайн эмч

С.Энхтуяа, Амгалан амаржих газрын Нярайн зөвлөх эмч, Нярайн эмч

О.Туул, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Мэдрэлийн эмгэг судлалын тасгийн эрхлэгч, Хүүхдийн мэдрэлийн эмч

Б.Болормаа, “Ирээдүй” хүүхэд мэдрэлийн клиник эмнэлгийн эмч, хүүхдийн мэдрэл эмч

Х.Мөнгөнцэцэг, Гурван гал эмнэлгийн хүүхдийн эмч

Б.Бүрэнжаргал, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлгийн Нярайн эмгэг судлалын тасгийн эрхлэгч

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
06 сарын 22 өдрийн дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ХҮҮХЭД, НЯРАЙ, УРГИЙН МЭС ЗАСЛЫН ҮНДЭСНИЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч:

Л.Ганбаяр, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эмнэлзүй эрхэлсэн тэргүүн дэд захирал

Нарийн бичиг:

Б.Баяраа, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий мэс заслын тасгийн эмч

Гишүүд:

А.Цэнджав, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий мэс заслын тасгийн эмч

Ж.Эрдэнэцогт Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүү нүүрний мэс заслын тасгийн эрхлэгч

Б.Дэлгэрмаа Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Чих хамар хоолойн мэс заслын тасгийн эрхлэгч

М.Болдбаатар Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Хүүхдийн гэмтлийн тасгийн эрхлэгч

М.Зоригбаатар, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Цээжний мэс заслын тасгийн эрхлэгч,

У.Хүрэлбаатар, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Бөөрний мэс заслын тасгийн эрхлэгч, зөвлөх зэргийн эмч

С.Баатарцогт, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Бөөрний мэс заслын тасгийн эмч

М.Ундром, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасгийн эрхлэгч, ахлах зэргийн эмч

А.Долгорсүрэн, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасгийн эмч

М.Батчимэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасгийн эмч

Э.Энхнаран, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Чих хамар хоолойн мэс заслын тасгийн эмч

Э.Ундрах, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Чих хамар хоолойн мэс заслын тасгийн эмч

Б.Батцэцэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нүдний мэс заслын тасгийн эмч

Б.Алтангэрэл, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүү нүүрний мэс заслын тасгийн эмч

Ч.Наранцэцэг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нярайн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч

Л.Ролзодмаа, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нярай судлалын тасгийн эрхлэгч

Б.Батцэнгэл, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нярайн эмгэг судлалын тасгийн эрхлэгч

Л.Аваажигмэд, Улсын гуравдугаар төв эмнэлгийн Мэдрэлийн мэс заслын тасгийн эрхлэгч

Л.Бат-Эрдэнэ, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Нурууны мэс заслын тасгийн эрхлэгч

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
05 сарын 20 өдрийн 11 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

ҮНДЭСНИЙ БАГИЙН АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл

Хүүхдийн өвчлөл, эндэгдэл нь тухайн улс орны хөгжлийн тувшнийг харуулах чухал үзүүлэлтийн нэг бөгөөд хүүхдийн эрүүл мэндэд оруулж буй хөрөнгө оруулалт нь улс орны хөгжлийг хангах алсын хараатай улс төр, эдийн засаг, нийгмийн бодлогын илэрхийлэл хэмээн үздэг.

Тогтвортой хөгжлийн зорилгыг амжилттай хэрэгжүүлэх, эх хүүхдийн сэргийлж болох нас баралтыг бууруулах чиглэлд төр засгаас шат дараалсан цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч хүүхдийн өвчлөл, эндэгдэл тууштай буурах явц хангалтгүй, улсын хэмжээнд бус нутгийн ялгавартай байдал хадгалагдсаар байна. Тодруулбал улсын хэмжээнд 2024 онд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насын хүүхдийн эндэгдлийн түвшин 15.2 промил байгаа нь өмнөх оноос 0.3 промилээр өссөн байна. Тав хүртэлх насын хүүхдийн эндэгдлийн түвшин хот хөдөөд ялгавартай буюу Улаанбаатар хотод 14.9 промил, хөдөө орон нутагт 15.5 промил байна. Тав хүртэлх насын хүүхдийн эндэгдлийн 60 орчим хувь, нялхсын эндэгдлийн 70 орчим хувийг нярайн эндэгдэл эзэлж байгаа тул тав хүртэлх насын хүүхдийн эндэгдлийг бууруулахын тулд нялхас ба нярайн эндэгдлийг бууруулах нь чухал байна.

Хүүхдийн эсэн мэнд амьдрахуй, эрүүл мэндэд тулгарч буй сорилтууд нь үндсэндээ үйлчилгээ авах боломж жигд бус, нэн шаардлагатай эм, хангамж хязгаарлагдмал, эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад нийгмийн бусад салбаруудын хамтын ажиллагаа дутмаг, эх, нярай, хүүхдийн өвчлөл, эндэгдэл алслагдсан, тусlamж, үйлчилгээний хүртээмжийн тэгш бус байдал, ядуу, эмзэг бүлгийн хүүхдүүд шилжилт хөдөлгөөнтэй холбоотой тусlamжаас хожимдох, орон нутагт тусlamж үйлчилгээний хүртээмж хангалтгүйгээс улсын чанартай томоохон эмнэлгүүдийг зорих, томоохон эрүүл мэндийн байгууллагын ачаалал нэмэгдэж, хүлээгдэл үүсэх зэрэг олон асуудал дагуулдаг. Хүүхэд, нярайн мэс заслын тусlamж үйлчилгээг орон нутагт нь хөгжүүлэх нь эрүүл мэндийн тусlamжийн тэгш хүртээмжтэй байдлыг хангах, цаг алдалгүй эмчлэх, нярайн эндэгдлийг бууруулахад чухал ач холбогдолтой.

Сүүлийн 3 жилд Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн хүүхдийн мэс заслын тасгуудын нийт мэс заслын 72,5%-г яаралтай мэс заслын тусlamж эзэлж байгаагаас арьс зөвлөн эдийн идээт эмгэг, мухар олгойн цочмог үрэвсэл, ясны үений идээт эмгэг, шүдний гаралтай идээт нэвчдэс, чих хамар хоолойн гадна биет, идээт эмгэгүүд, нүд орчмын идээт эмгэг, тэмсөг хуухнагийн цочмог эмгэгүүд зонхилон тохиолдож байна. Яаралтай мэс заслын тусlamж авсан хүүхэд нярайн 67% нь Улаанбаатар хотын дүүргүүдээс ирсэн бол 33% нь аймаг орон нутгаас ирж мэс заслын тусlamж авчээ.

Цаашид хүүхдийн өвчлөл эндэгдлийг тогтвортой, тууштай бууруулахын тулд эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг дээшлүүлэх, мэргэжил аргазүйн

дэмжлэг туслалцаа үзүүлэх, орон нутагт нэн хэрэгцээтэй байгаа хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн тусlamж үйлчилгээг бэхжүүлэх, тусlamж үйлчилгээний чанар хүrtээмжийг сайжруулах, хүлээгдлийг бууруулах, тулгамдсан асуудлаар бодлогын санал зөвлөмж өгөх, эмч мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг тасралтгүй дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, гадаад улсад эмчилгээнд явах иргэдийн урсталыг бууруулах, төвлөрлийг сааруулах, үндэсний баг байгуулан ажиллах шаардлагатай байна.

Хоёр. Зорилго

Улсын хэмжээнд хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлгээс үзүүлж буй нэн шаардлагатай тусlamж, үйлчилгээг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт нутагшуулж, орон нутагт тусlamж, үйлчилгээний чанар, хүrtээмжийг сайжруулж, төвлөрлийг сааруулах.

Гурав. Зорилт.

1. Хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн эмч нарын тусlamж үйлчилгээний хүрээг тэлэх, мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах, туршлага солилцох;
2. Хүлээгдэл ихтэй хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн зарим тусlamж, үйлчилгээг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт бэхжүүлэх нэхцэл бүрдүүлэх, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв бүрийг хүүхдийн эмчтэй болгох чиглэлд дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
3. Хүүхдийн мэс заслын мэргэшлийн хүлээгдэл ихтэй зарим тусlamж, үйлчилгээг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт үзүүлдэг болох, цаашид тогтвортой үзүүлэх нэхцэл бүрдүүлэх; Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг дээрх төрөлжсөн мэргэшлийн чиглэлүүдээр ажлын байран дээр нь болон дагалдуулан сургаж, чадавхжуулах;
4. Бусчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд орон нутагт, Улаанбаатар хотод нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвд хүүхдийн мэс заслын төрөлжсөн тусlamжийг бэхжүүлэх;
5. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв бүрд хүүхэд, нярайн яаралтай тусlamж, эрчимт эмчилгээний тасаг эсвэл нэгжийг тооцоо судалгаанд үндэслэн байгуулан ажиллуулахад мэргэжил аргазүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх.

Дөрөв. Үйл ажиллагаа

1. Орон нутаг, дүүргийн эрүүл мэндийн төвийн хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн тусlamж, үйлчилгээ, шинээр нэвтрүүлэх технологи, тоног төхөөрөмж, сургалтын шаардлага хэрэгцээг тодорхойлох;
2. Хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн эмч нарын үндэсний баг нь мэргэжлийн шаардлагатай тусlamж үйлчилгээний хүрээг тэлэх зорилгоор сэлгүүлэн болон багаар хамтран ажиллах;

3. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт үндэсний багаас очиж ажиллан, хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн чиглэлийн дагуу нэн шаардлагатай тусlamж, үйлчилгээг үзүүлэх;
4. Үндэсний багаас хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг дагалдуулан сургаж, дадлагажуулах;
5. Шаардлагатай тохиолдолд үндэсний багт бусад мэргэжлийн эмч нарыг татан оролцуулна.

"Хүүхэд нярайн үндэсний баг"-ийн үйл ажиллагааны чиглэл:

1. Эрүүл мэндийн байгууллагуудын хүүхэд, нярай, өсвөр үеийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний төлөв байдал, Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтэд тогтолцооны дүн шинжилгээ хийх, тусlamж дэмжлэг үзүүлэх санал зөвлөмж боловсруулах.
2. Улаанбаатар хот болон орон нутагт хүүхэд, нярай, өсвөр үеийн тусlamж үйлчилгээ үзүүлэгч эмч мэргэжилтнүүдэд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх, мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зохион байгуулах.
3. Хүүхэд, нярайн эмнэл зүйн тусlamжийн тулгамдсан асуудлаар нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний заавар, зөвлөмж, удирдамж боловсруулан, түгээн дэлгэрүүлэх.
4. Хүүхэд, нярайн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний талаар бодлогын санал, зөвлөмж боловсруулахад оролцож санал зөвлөмж өгөх
5. Хүүхэд, нярайн эрдэм судлалын ажил болон өвчлөлөөс сэргийлэх, эрт илрүүлэх, нийгмийн эрүүл мэндийн интервенц хэрэгжүүлэхэд санал дүгнэлт гаргах.

"Хүүхэд, нярай, ургийн мэс заслын үндэсний баг"-ийн үйл ажиллагаа

1. Хүүхэд, нярай, ургийн мэс заслын үндэсний багийн төрөлжсөн мэргэшлийн эмч нар нь мэргэжлийн шаардлагатай тусlamж үйлчилгээний хүрээг тэлэх зорилгоор сэлгүүлэн болон багаар хамтран ажиллах;
2. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт үндэсний багаас очиж ажиллан төрөлжсөн мэргэшлийн чиглэлийн дагуу нэн шаардлагатай тусlamж, үйлчилгээг үзүүлэх, лекц, сургалт хийх, ажлын байрны дагалдан сургалт;
3. Үндэсний багаас хүүхдийн мэс заслын төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг 3-6 сарын хугацаанд дагалдуулан сургаж дадлагажуулах;
4. Орон нутаг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэгт хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн тусlamж, үйлчилгээ, шинээр бэхжүүлэх технологи, багаж тоног төхөөрөмжийн, сургалтын, хүний нөөцийн шаардлага хэрэгцээг тодорхойлох;

Тав. Хугацаа

2025 оны 6 дугаар сарын 2-ны өдрөөс 2027 оны 6 дугаар сарын 2-ны өдөр

Зургаа. Хамрах хүрээ

Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллага

Долоо. Хүрэх үр дүн

1. Хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн зарим тусlamж, үйлчилгээг нэн хэрэгцээтэй байгаа чиглэлээр төвлөрөл бий болсон бус нутгуудад тусlamж, үйлчилгээг багаар үзүүлэх, ажлын байрны дадлагажуулах сургалт зохион байгуулсан байна.
2. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн зарим тусlamж, үйлчилгээг бие дааж үзүүлэх чадавх бүрдэж, орон нутгийн хүүхдүүд амьдарч буй бус нутгаасаа тусlamж, үйлчилгээг чирэгдэлгүй авах боломж бүрдэнэ.
3. Хүүхдийн төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлгүүдийн тусlamж, үйлчилгээний төвлөрөл, хүлээгдэл буурсан байна.
4. Хүүхэд, нярай, ургийн мэс заслын багийн төрөлжсөн мэргэшлийн тусlamж үйлчилгээний үндэсний багийн хамтын үйл ажиллагаа өргөжнө.
5. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт нэн шаардлагатай Хүүхэд, нярай, ургийн мэс заслын төрөлжсөн мэргэшлийн тусlamж, үйлчилгээг үзүүлдэг болсон байна.
6. Хүүхэд нярайн төрөлжсөн мэргэшлийн тусlamжийг аймаг, дүүргийн эмнэлгүүдэд үзүүлснээр төвлөрөл, хүлээгдэл буурч, үйлчлүүлэгч оршин суугаа газартаа хүүхдийн яаралтай мэс заслын тусlamж, зонхилон тохиолдох зарим эмгэгийн тусlamжийг авах боломж бүрдэнэ.
7. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн төвлөрөл хүлээгдэл буурснаар хүүхдийн мэдрэлийн мэс засал, зүрхний мэс засал, эрхтэн шилжүүлэх мэс засал, хавдрын мэс засал, гэмтлийн мэс заслын тусlamжийг хүүхэд, нярайд далайцтай үзүүлэх боломж бүрдсэн байна.
8. Гадаадад эмчлүүлэх Хүүхэд, нярай, ургийн мэс заслын эмгэгийн тоог бууруулсан байна.
9. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд шинэ технологи нэвтрүүлэх, багаж тоног төхөөрөмжийн хангарт сайжрах, 6 аймгийн нэгдсэн эмнэлэг, 1 дүүргийн эмнэлэгт хүүхдийн яаралтай мэс заслын тусlamж ба зонхилон тохиолдох зарим эмгэгт тусlamж үзүүлэх багаж тоног төхөөрөмжийн хангарт сайжирна.
10. Аав, ээж, асран хамгаалагчид хүүхэд нярайн төрөлхийн гаж хөгжил, зонхилон тохиолдох эмгэгүүдийн талаарх мэдлэг, мэдээлэлтэй болон хүүхэд нярайн эрүүл мэндийн боловсролтой болсон байна. Хэвлэл мэдээлэл, телевиз, нийгмийн сүлжээнд хүүхэд судлал, хүүхэд нярай, ургийн мэс заслын тухай цуврал мэдээлэл, нэвтрүүлэг, контент бэлтгэж гаргасан байна.